



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 765

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 986,469.44 (есөн зуун наян зургаан мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Өвөрхангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг түр хавсран гүйцэтгэгч Б.Батбаяр, Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Эрдэнэсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Д.Д. Нарангэрэл

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

13301672

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2020 оны 12  
дугаар сарын 28-ны өдрийн 765  
дугаар тогтоолын хавсралт

**"Өвөрхангай-АЗЗА" ТӨХК-ийн балансаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Худаг АН-01	2005	901,246.50	300,415.50	5 жил
2	Худаг АН-01-02	2005	85,222.94	28,407.65	5 жил
			986,469.44	328,823.15	
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		986,469.44 (есөн зуун наян зургаан мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө)	328,823.15 (гурван зуун хорин найман мянга найман зуун хорин гурван төгрөг арван таван мөнгө)	